

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 2 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДРИЙН 02 ДУГААР ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ ТАНИЛЦУУЛГА

Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар үйлийн 20.2 дахь хэсэг, мөн хуулийн 20.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, үүний нэмэгдэл олгох журам” -ын 5, 6 дахь заалтын дагуу төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, 2015 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг тус тусүндэслэн хавсралтад дурьдсан яам, агентлагын нэр бүхий төрийн албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэвийг шинээр олгох болон ахиулахаар дүгнэлт гарган танилцуулж байна. Үүнд:

1. Уул уурхайн яам: Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэвийг 11 албан хаагчид шинээр, 12 албан хаагчид ахиулах саналыг ирүүлсний Төрийн нарийн бичгийн дарга 1, газрын дарга 2, хэлтсийн дарга 2, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 17 байна.

Үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “А” буюу “маш сайн” гэсэн үнэлгээтэй 23 албан хаагч байна.

Албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгуулах, ахиулах талаар газруудаас ирүүлсэн саналыг судлаж үзээд Тэргүүн түшмэлийн гутгаар зэрэг 1, Эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг 4, тэргүүн зэргийн Ахлах түшмэлийн гутгаар зэрэг-2, дэс түшмэлийн тэргүүн зэрэг-3, дэд зэрэг-2, гутгаар зэрэг-3, дэс түшмэлийн дөтгөөр зэрэг-8 нийт 23 албан хаагчид төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгуулахаар санал оруулж байна.

Зэрэг дэв алгасуулан ахиулахаар санал ирүүлсэн 1 албан хаагчийн хувьд ажилласан жил, албан тушаалын байдлаар зэрэг дэв алгасуулан олгохүндэслэлгүй байх тул олгоогүй болно. /ТБЗГ-ын ахлах мэргэжилтэн А.Пүрэв./

2. Ашигт малтмалын газар: Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэвийг 9 албан хаагчид шинээр, 20 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулахаар санал ирүүлсний хэлтсийн дарга 4, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн 25 байна.

Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “А” буюу “маш сайн” гэсэн үнэлгээтэй 24, “В” буюу “хангалттай” гэсэн үнэлгээтэй 5 албан хаагч байна.

Албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгуулах, ахиулах талаар Ашигт малтмалын газраас ирүүлсэн саналыг судлаж үзээд ахлах түшмэлийн тэргүүн зэрэг-1, дэд зэрэг-2, гутгаар зэрэг-1, дэс түшмэлийн тэргүүн зэрэг-3, дэд зэрэг-3, гутгаар зэрэг-10, дөтгөөр зэрэг-9, нийт 29 албан хаагчдад өрийн захи ргааны албан хаагчийн зэрэг дэв олгуулахаар санал оруулж байна.

3. Газрын тосны газар: Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэвийг 22 албан хаагчид ахиулах саналыг ирүүлсний дотор газрын дарга 1, хэлтсийн дарга 5, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн 16 байна.

Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “А” буюу “маш сайн” гэсэн үнэлгээтэй 22 албан хаагч байна.

Албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгуулах, ахиулах талаар Газрын тосны газраас ирүүлсэн саналыг судлаж үзээд Тэргүүн түшмэлийн гутгаар зэрэг 1,

ахлах түшмэлийн тэргүүн зэрэг-1, дэд зэрэг-1, гутгаар зэрэг-3, дэс түшмэлийн тэргүүн зэрэг-4, дэс түшмэлийн дэд зэрэг-7, дэс түшмэлийн гутгаар зэрэг-6 нийт 22 албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгуулахаар санал оруулж байна.

Жагсаалтыг хавсаргав.

Хавсралтад заагдсан нэр бүхий төрийн албан хаагчдад өрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэвийг шинээр олгох болон ахиулах асуудлыг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2.5 дахь заалтын дагуу хэлэлцэж эрх бүхий албан тушаалтанд санал дүгнэлт гаргаж өгөхийг хүсье.

АЖЛЫН ХЭСЭГ